

БАТЛАВ.
“ГҮНИЙ-УС” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.ЭНХЧИМЭГ

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Байгууллагын нэр		Хэсгийн нэр	
“Гүний-ус” ХХК		Цэвэрлэх байгууламжийн хэсэг	
Ажлын байрны нэр		Хавсран гүйцэтгэх ажил	Дугаар
Лаг боловсруулах ажилтан			1
Шууд харьяалагдах ажлын байр		Шууд харьяалах албан тушаал	
Гүйцэтгэх захирал		Үйлдвэрлэл үйлчилгээний хэсэг, түүний ажилчид	
Ажлын байрны зорилго	Компанийн зорилт, эрхэм зорилгыг эрхэмлэн ажиллах		

1. Ажлын байрны үндсэн чиг үүрэг:

1. Байгууллагаас зохиосон мэргэжлийн болон бусад арга хэмжээнд идэвхитэй оролцох, шаарлагатай тохиолдолд үйлдвэрийн аль ч объектод ажил амралтын ямарч нөхцөлд бэлэн байхын зэрэгцээ, ээлжийн амралтаа зохицуулан илүү цагаар ажиллах
2. ХХАА-ны үе шатны зааварчилгууд, нийтийн аж ахуйн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, стандартыг ажилдаа мөрдлөг болгон осол, аваар зөрчилгүй ажиллах
3. Хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгыг мөрдөн ажиллах
4. Ажил үйлдвэрлэлийн технологийн горимыг хатуу баримталж, ажлын бүтээмжийг өндөр байлгах, ажлын цагийг баримтлах, ажлын байрыг дур мэдэн орхих, чөлөө зөвшөөрөлгүй явах, ажил таслах, чөлөөний хугацаа хэтрүүлэх, ажилтан болон бусдад сөрөг нөлөөлөл учруулахгүйгээр ажиллаж, хөдөлмөрлөх
5. Үйлдвэрлэлийн осол, гэмтэлд өртөхгүй байхын тулд мөрдөж ажиллах “БҮҮ МАРТ-10” зарчмыг ажилдаа хэвшүүлж ажиллах
6. Өөрийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг байнга төлөвлөлттэйгөөр хөгжүүлж, сорилын болон улирал тутамд зохион байгуулагдах мэргэжлийн, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шалгалтанд манлайлж ажиллах
7. Хууль журам, дүрэм, стандарт, заавар, зааварчилгыг уншин судлан, өөрийн болгож улирал тутам мэргэжлийн сургалт, шалгалтанд хамрагдаж ажиллах
8. Байнгын болон орон тооны бус комисс, ажлын хэсэгт ажиллах ба ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг ханган үр дүнг удирдлагад тайлагнаж, мэдээ тайланг гаргаж ажиллах
9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах ба Цэвэр бохир усны техникийн бүлэг, Уст цэгийн хамгаалах бүлгийн бие бүрэлдэхүүнд бэлэн байхын зэрэгцээ хээрийн сургууль, дадлага сургууль, өндөржүүлсэн буюу онц байдал зарласан үед шуурхай арга хэмжээ авч, удирдлага, зохион байгуулалтаар хангагдан ажиллах
10. Учирч болзошгүй эрсдэлээс сэрэмжлэн, аюулыг мэдээлж, илэрсэн зөрчил, гэмтлийг тухай бүрт нь мэргэжлийн ажилчнаар засварлуулан ажиллах
11. Ажлын байран дахь цахилгааны болон галын аюулгүй байдлыг ханган ажиллах
12. Ажил үүрэг гүйцэтгэж байгаа тухайгаа ээлжийн диспетчерт заавал мэдэгдэж, бүртгүүлж ажиллах

2. Ажлын байрны чиг үүрэг:

1. Цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалтыг бүрэн хариуцаж ажиллах
2. 1,2,3-р өргөтгөлийн зангилаанаас цэвэрлэх байгууламж хүртлэх бохир усны шугам хоолой, худагт өдөр тутам үзлэг хийх
3. Ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээ, худаг, камерын ашиглалтын бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг хариуцаж ажиллана
4. Бохир усны шугам хоолой, худгуудад өдөр тутам үзлэг хийж, илэрсэн гэмтлийг даруй засварлахын зэрэгцээ их хэмжээний аваар ослын үед шалтгааныг даруй тогтоон инженер техникийн ажилтанд мэдэгдэх
5. Байгууллагын мэдэлд буй барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалттай холбогдсон гэмтэл гархаас сэргийлэх, хяналт тавих, тодорхой мэдээллээр удирдлагыг хангах
6. Хот суурингийн усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах
7. Аж ахуй нэгж, албан байгууллага, орон сууцны бохир усны худаг, шугам сүлжээний бүрэн бүтэн байдалд хяналт тавих
8. Байгууллага, аж ахуй нэгж, айл өрхөд дуудлагаар засвар үйлчилгээг хийсэн үед төлбөрт үйлчилгээний тооцоог диспетчерээр хянуулан санхүүтэй тооцоо хийх
9. Өөрийн эзэмшилд байгаа багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах
10. Байгууллагын эзэмшилд байгаа бохир усны худгыг сард нэг удаа лайдаж цэвэрлэх
11. Даланзадгад хотын инженерийн хийцлэл бүхий барилга байгууламж, шугам сүлжээний схем зургийг мэддэг байх

3. Ажлын байранд тавигдах шаардлагууд:

Ерөнхий шаардлага	Мэргэжил	Сантехникийн засварчин
	Боловсрол	Бүрэн бус дунд
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> Харилцааны болон хамтран ажиллах чадвартай Тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх чадамжтай Ачаалал даах чадвартай, сэтгэмжтэй Гаж зуршилгүй, тогтвортой ажиллах Аливаад эе эвийг олох чадамжтай
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдаж ажиллах Эд хөрөнгө эзэмших гэрээг аж ахуйн няравтай байгуулж ажиллах 	
Ажлын байрны	Санхүү	<ul style="list-style-type: none"> Албан тушаалын цалин, нэмэгдэл, нөхөн төлбөр, тусламж, тэтгэмж, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллах Монгол улсын хэмжээнд мөрдөж байгаа Засгийн Газраас тогтоосон Хөдөлмөрийн хөлсний өөрчлөлтийг мөрдөж ажиллах Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг хариуцах

нөөц хэрэгсэл	Ажлын байр	<ul style="list-style-type: none">• Гэнэтийн ослын даатгалд даатгуулах• Шаардлагатай тохиолдолд унаанд шатахуун, утсанд нь ярианы эрх буюу нэгж олгоно• Мэргэжлийн болон ур чадварын сургалтанд хамруулах• Багаж, сэлбэг хэрэгслээр хангана.
Ажлын байрны нөхцөл: Хортой		
Ажлын байр: Лаг боловсруулах ажилтан		

4. Ажлын байрны тодорхойлолт:

Боловсруулсан:	Хянасан:
Хүний нөөцийн менежер:	Ерөнхий инженер: С.Отгончулуун/